



Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалтын газар,
Үнэлгээний мониторингийн газар

ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨᠢ
ᠮᠣᠨᠢᠲᠤᠭᠡᠨᠢ
ᠮᠣᠨᠢᠲᠤᠭᠡᠨᠢ
ᠮᠣᠨᠢᠲᠤᠭᠡᠨᠢ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭ

(УИХ-ын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаагаар)
/2024 оны 10.01-2025.01.28/

Улаанбаатар хот
2025 он

НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ

4.2. БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

ТАВ. ХЯНАЛТЫН СОНСГОЛ

5.1. ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ

5.2. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХТАЙ ХОЛБООТОЙ

ЗУРГАА. ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ

6.1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

6.2. УЛСЫН ИХ ХУРАЛД АЖЛАА ХАРИУЦАН ТАЙЛАГНАДАГ БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

6.3. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ ДОЛОО. ТӨСВИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

7.1. ТӨСВИЙН ХЯНАЛТ

7.2. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, УЛСЫН ТӨСВИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

7.3. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

Намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын захирамжаар байгуулагдсан тодорхой асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн боловсруулах нийт 26 ажлын хэсэг. Үүнээс:


-УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан - 17;

-Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан - 9;

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцан, хяналт шалгалт явуулж, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий нийт ажлын хэсэг **26** байгуулагдан ажилласнаас Улсын Их Хурлын даргын захирамжаар **17** ажлын хэсэг, Байнгын хорооны тогтоолоор **9** ажлын хэсэн байгуулагдан ажилласан болно.

График 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

● УИХ-ЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ
● БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ



Хүснэгт 1. Хяналт шалгалтын чиглэлээр байгуулагдсан нийт ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

ХУГАЦАА	УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ	БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ
2024 онд байгуулагдсан	17	9
Нийт - 26	17	9

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	УИХ-ын даргын захирамж 2024.08.19, №42 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.4-т заасан зорилт, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбогдох арга хэмжээний санал болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 15 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: М.Мандхай Гишүүд: Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, П.Батчимэг, М.Ганхүлэг, Б.Заяабал, Ц.Идэрбат, С.Лүндэг, З.Мэндсайхан, Л.Соронзонболд, Р.Сэддорж, А.Ундраа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, Р.Батболд
2.	УИХ-ын даргын захирамж 2024.08.27, №59 Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний санал боловсруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 7 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярбаатар Гишүүд: Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, П.Ганзориг, М.Ганхүлэг, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара
3.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №73 Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 13 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Г.Дамдинням Гишүүд: Б.Баярбаатар, Ж.Алдаржавхлан, Ж.Баярмаа, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жаргалан, С.Замира, С.Зулпхар, Ц.Мөнхбат Н.Наранбаатар /2024 оны 307-р захирамжаар хассан/, П.Сайнзориг, Б.Хэрлэн
4.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №75 Нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, цэгцлэх талаар санал, дүгнэлт гарган холбогдох бусад хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	УИХ-ын 18 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Ж.Бат-Эрдэнэ Гишүүд: Б.Баярбаатар, Ж.Золжаргал, Ч.Анар /2024 оны 307-р захирамжаар хассан/, О.Батнайрамдал, Ч.Лодойсамбуу, Б.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаясгалан, Х.Баасанжаргал, М.Нарантуяа-Нара, Х.Ганхуяг, Г.Очирбат, Ж.Ганбаатар, М.Сарнай, Б.Жаргалан, Дав.Цогтбаатар, Д.Жаргалсайхан, С.Цэнгүүн, Д.Энхтүвшин

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
5.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №78 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 14 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: С.Лүндэг Гишүүд: Б.Пүрэвдорж, Б.Бейсен, Дам.Цогтбаатар, М.Бадамсүрэн, Ж.Батжаргал, Б.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, С.Замира, Н.Наранбаатар, Д.Рэгдэл, Б.Түвшин, Б.Уянга, Н.Батсүмбэрэл
6.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №79 Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 7 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Б.Уянга Гишүүд: Ж.Золжаргал, Э.Болормаа, М.Ганхүлэг, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Д.Рэгдэл
7.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №81 Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 11 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: М.Ганхүлэг Гишүүд: Ч.Ундрэм, Н.Алтаншагай, Ш.Бямбасүрэн, Н.Батсүмбэрэл, Э.Батшугар, Э.Болормаа, М.Сарнай, Г.Лувсанжамц, С.Цэнгүүн, Ө.Шижир
8.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №82 Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 8 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Д.Батлут Гишүүд: С.Ганбаатар, Н.Алтанхуяг, Ж.Батжаргал, Ж.Ганбаатар, М.Ганхүлэг, С.Замира, С.Лүндэг
9.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №83 Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт гаргаж, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 9 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Х.Ганхуяг Гишүүд: Р.Сэддорж, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Б.Заяабал, У.Отгонбаяр, Г.Очирбат, Г.Хосбаяр
10.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №97 Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, нийгмийн халамжийн тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 14 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Б.Жаргалан Гишүүд: Б.Бейсен, Л.Энхнасан, Н.Алтаншагай, Р.Батболд, Ж.Баясгалан, Д.Ганмаа, М.Ганхүлэг, С.Зулпхар, П.Мөнхтулга, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, Б.Түвшин, М.Сарнай /2024 оны 307 захирамжаар нэмсэн/

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
11.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №103 Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 19 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Г.Тэмүүлэн Гишүүд: А.Ариунзаяа, Р.Батболд, П.Батчимэг, Э.Болормаа, С.Зулпхар, Б.Жаргалан, Б.Пунсалмаа, Б.Уянга, Б.Хэрлэн, Р.Сэддорж, Ц.Мөнхтуяа, Б.Мөнхсоёл, Ч.Лодойсамбуу, Н.Наранбаатар, Л.Энхнасан, Д.Энхтүвшин, С.Эрдэнэбат, Н.Номтойбаяр
12.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №110 Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 6 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: О.Номинчимэг Гишүүд: Д.Батбаяр, Г.Дамдинням, Х.Жангабыл, Б.Мөнхсоёл, М.Сарнай
13.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №111 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 8 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтүвшин Гишүүд: Т.Аубакир, Н.Алтанхуяг, Д.Батбаяр, Б.Баярбаатар, С.Ганбаатар, Б.Заяабал, Ө.Шижир
14.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №113 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 5 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: У.Отгонбаяр Гишүүд: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Х.Болормаа, Э.Болормаа
15.	УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №115 Иргэний хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 8 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: О.Номинчимэг Гишүүд: Дам.Цогтбаатар, Х.Тэмүүжин, Г.Уянгахишиг, Х.Баасанжаргал, Б.Энхбаяр, П.Сайнзориг, С.Эрдэнэболд
16.	УИХ-ын даргын захирамж 2024.11.18, №263 Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсвийн төслийг боловсруулах болон төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх журмын талаар санал, дүгнэлт гаргаж, төсвийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах чиглэлээр хуулийн төсөл боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 25 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Х.Булгантуяа Гишүүд: Т.Аубакир, Р.Батболд, О.Батнайрамдал, Ж.Баярмаа, Ж.Галбадрах, Д.Ганмаа, Б.Жаргалан, Д.Жаргалсайхан, Ц.Идэрбат, М.Мандхай, Г.Тэмүүлэн, Б.Мөнхсоёл, Ц.Мөнхтуяа, У.Отгонбаяр, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, Ч.Ундрам, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, Б.Уянга, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг, С.Эрдэнэболд

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
17.	УИХ-ын даргын захирамж 2024.12.02, №292 Татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 9 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Х.Ганхуяг Гишүүд: Т.Аубакир, Р.Батболд, Ж.Баясгалан, П.Ганзориг, Б.Заяабал, О.Номинчимэг, Б.Пунсалмаа, Д.Энхтүвшин

2.1.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны товч мэдээлэл



УИХ-ын 2024 оны намрын ээлжит чуулганы болон завсарлагааны хугацаанд ажилласан Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл:


1. УИХ-ын даргын захирамж 2024.08.19, №42

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4.2, 4.4-т заасан зорилт, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх бодлого, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, холбогдох арга хэмжээний санал болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг:

Товч мэдээ:

- 2024.08.20-2025.01.22 хооронд ажлын хэсэг 12 удаа хуралдаж, 2 хэлэлцүүлэг, 1 эрдэм шинжилгээний хурал зохион байгуулжээ.
- 2024.09.08-12 Говь-Алтай аймгийн хэд хэдэн суманд ажилласан.
- 2024.10.04 “Тана” ШУ-ны хүрээлэнтэй хамтран хэлэлцүүлэг хийсэн.
- 2024.10.21 “Ноос, ноолуур ба арьс, ширний үйлдвэрлэл” сэдвээр эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан.
- 2024.11.20 “Цагаан алт, хүнсний хувьсгал” сэдвээр хэлэлцүүлэг хийсэн.

2. УИХ-ын даргын захирамж 2024.08.27, №59



Мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах арга хэмжээний санал боловсруулах, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.09.13-2025.01.17 хооронд ажлын хэсэг 12 удаа хуралдаж, 4 хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

2.1.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны товч мэдээлэл

- 2024.09.12-13 Дархан-Уул, Сэлэнгэ аймагт ажиллаж, тариаланчидтай уулзсан.
- 2024.09.26 Нарантуул, Барс захуудад ажиллаж, гурилын үнэ, худалдааны нөхцөл байдлын талаар санал солилцсон.
- 2024.10.18 Монополын эсрэг газар, тариалан эрхлэгчдийн холбоотой уулзалт хийсэн.
- 2024.11.27 “Газар тариалангийн салбарын өнөөгийн байдал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- 2024.12.12 Гурилын үйлдвэрүүдийн төлөөлөлтэй “Өглөөний цай” хэлэлцүүлэг хийсэн.



3. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №73

Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль, тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.10.02-2024.11.22 хооронд ажлын хэсэг дараах ажлуудыг хийжээ.
- 2024.10.17 БНСУ-ын Хүний нөөцийн удирдлагын яам, ЭЗХАХБ-тай хамтарсан олон улсын хуралд оролцсон.
- 2024.11.21 БНСУ-ын Үндэсний Ассамблейн үйл ажиллагаатай танилцаж, гишүүдтэй уулзсан.
- 2024.11.22 БНСУ-ын Төрийн албаны шалгалтын төвийн үйл ажиллагаатай танилцаж, санал солилцсон.



4. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №78

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.10.18-2024.10.21-ний хооронд ажлын хэсэг 2 удаа хуралдаж дараах ажлуудыг гүйцэтгэсэн.
- 2024.10.18 Ажлын хэсгийн ахлагч олон улсын байгууллагын төлөөллийг хүлээн авч, олон улсад хийгдсэн судалгааны талаар ярилцсан.
- 2024.10.21 Хуралдаанаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэдээлэл сонсож, ажлын хэсгийн удирдамж, төлөвлөгөөний талаар хэлэлцсэн.
- Ажлын хэсэг Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэгийн хуульч, судлаач нартай хамтран Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн судалгаа хийлгэхээр төлөвлөж байна.

2.1.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны товч мэдээлэл



5. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №79

Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.09.18-2024.12.17 хооронд ажлын хэсэг 5 удаа хуралдаж, дараах ажлуудыг хийжээ.
- 2024.09.23 Ундны ус, ариун цэврийн байгууламжийн талаар 25 байгууллагад мэдээлэл ирүүлэх албан бичиг хүргүүлсэн.
- 2024.10.16 Ус хөтөлбөрийн үр дүнгийн талаар мэдээлэл сонсож, холбогдох байгууллагуудад албан бичиг илгээсэн.
- 2024.11.11-12 “Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилт” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- 2024.12.17 Мянганы сорилтын сангийн усны төслүүдийн хэрэгжилттэй танилцсан.

6. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №81

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.10.03 “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт” болон залуучуудад тулгамдсан асуудлын талаар хэлэлцсэн.
- 2024.10.16 ПСХХ-д залуучуудын хөгжлийн талаар харьцуулсан судалгаа хийх албан бичиг хүргүүлсэн.
- 2024.11.21 – Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны бодлого, үйл ажиллагаатай танилцсан.
- 2025.01.15 “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан.



7. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №82


Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.11.14 Ажлын удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцсэн.
- 2025.01.14 ЖДҮГ-ын танилцуулгыг сонссон.
- 2025.01.15 Хуулийн хэрэгжилттэй холбоотой гадны туршлагын судалгаа хийхээр ПСХХ-д захиалга өгсөн.
- 2025.01.22 Орон нутагт ажиллах удирдамж баталсан.
- 2025.01.23 6 аймгийн Засаг дарга нарт хамтран ажиллах албан бичиг хүргүүлсэн.
- УИХ-ын дарга болон ОУ-ын хөгжлийн байгууллагуудад дэмжлэг хүссэн албан тоот тус хүргүүлсэн.



2.1.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны товч мэдээлэл



8. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №83

Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт гаргаж, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- Ажлын хэсэг 2024.10.02 - 2024.12.24 хооронд дараах ажлуудыг хийв.
- 2024.10.02-03 “Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр салбаруудын хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- 2024.10.14 Төрийн байгууллагуудтай цуврал уулзалт хийж эхэлсэн.
- 2024.12.03-04 Байгаль орчин, санхүү, эдийн засаг, зам тээвэр, боловсрол, аж үйлдвэр, хөдөлмөр, нийгмийн хамгаалал зэрэг салбаруудын асуудлыг ангилан хэлэлцсэн.
- 2024.12.16 Хууль зүй, батлан хамгаалах, эрүүл мэнд, эрчим хүч, хөдөө аж ахуй зэрэг салбаруудын мэдээллийг сонссон.
- 2024.12.17 Судалгааны багийн тайланг сонсож, орон нутгийн удирдлагуудтай цахимаар хуралдсан.
- 2024.12.20 Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцсэн.
- 2024.12.24 ЭЗБХ-нд танилцуулга хийж, Байнгын хорооны 7 дугаар тогтоол батлагдсан.
- Тогтоолын агуулга: “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай”



9. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №97

Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, нийгмийн халамжийн тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.09.18 Ажлын хэсгийн ахлагч орон нутагт ажиллаж байсны дараа захирамжийг танилцуулж, нийгмийн халамжийн хуулийн зохицуулалттай холбоотой товч мэдээлэл бэлтгэж танилцуулсан.
- 2024.09.25-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад хандан мэдээлэл хүсэх тухай албан бичгийг хүргүүлж, гишүүдэд танилцуулсан.
- 2024.10.15- Хуралдаанаар Нийгмийн халамжийн хуулийн хэрэгжилтийн талаар ГБХНХЯ-ны мэдээлэл сонссон.



10. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №103

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.09.18 Ажлын хэсгийн ахлагч орон нутагт ажиллаж байсны дараа 2024.09.12 – Ажлын хэсгийн ахлагчид захирамж танилцуулж, хэрэгжүүлэх ажлын чиглэл өгсөн.
- 2024.11.15 Ажлын хэсгийн гишүүд Өмнөговь аймгийн Цогтцэций суманд болсон “Хариуцлагатай уул уурхай” чуулганд оролцож, уул уурхайн ажилтнуудтай уулзалт хийсэн.
- 2024.11.19 ГБХНХЯ, ХЭҮК-ийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгаа, өргөдөл, гомдлын талаар мэдээлэл сонссон.
- 2024.12.24 ГБХНХЯ-ны “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэг-2024” танилцуулга сонссон.

2.2.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны товч мэдээлэл



11. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №110

Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, электрон тамхи, түүнтэй холбоотой асуудлаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг судлан, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- Ажлын хэсэг 2024.09.30-2025.02.04 хооронд дараах ажлуудыг хийсэн.
- 2024.09.30 Ажлын хэсгийн хуралдаанаар Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнгийн талаарх мэдээлэл сонссон.
- 2024.10.03 Ажлын хэсгийн гишүүд ДЭМБ-тай уулзалт хийсэн бөгөөд ДЭМБ-аас "Who report on the global tobacco epidemic" тайлан 2021, 2023 он. "Tobacco tax policy and administration" тайлан зэрэг мэдээллийг авч ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.
- 2024.12.17 Ажлын хэсгийн гишүүд Сангийн яам болон Гаалийн ерөнхий газрын мэргэжилтнүүдтэй уулзаж. Тамхин бүтээгдэхүүнд ноогдуулж буй татварын бодлого болон тамхин бүтээгдэхүүний импортын талаарх мэдээллийг сонссон.
- 2024.12.23 Ажлын хэсгийн гишүүд ДЭМБ-ын төлөөлөлтэй хамтран "Tea meeting" уулзалт зохион байгуулсан бөгөөд. Тус арга хэмжээний хүрээнд Бээжин хотын Тамхины хяналтын тухай хуулийн төслийг боловсруулж батлуулсан мэргэжилтний туршлагын талаар сонсож, харилцан санал солилцсон.
- 2025.01.27-2025.01.28 – "Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг ДЭМБ-тай хамтран зохион байгуулсан.

12. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №111

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, холбогдох санал, дүгнэлт, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.09.12 Ажлын хэсгийн ахлагч Төрийн хяналт шалгалтын тогтолцооны талаарх бүрэн зураглал гаргаж танилцуулсан.
- 2024.10.02 Хуралдаанаар ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар болон судалгааны байгууллагад захиалгаар хийлгэх ажлын даалгаврыг хэлэлцсэн.
- 2024.10.10 Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс ирүүлсэн 12 судалгааны материалыг ажлын хэсэгт хүргүүлсэн.
- Төрийн захиргааны төв болон байгууллагуудын хяналт, шалгалтын тогтолцоо, тулгамдаж буй асуудлуудын талаар уулзалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж, хөтөлбөрийн төслийг боловсруулсан.
- 2024.11.05 Хуралдаанд холбогдох 11 байгууллагын танилцуулгыг сонссон.
- 2024.12.04 Хуралдаанаар ажлын удирдамж, төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

13. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №113

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.10.01 ЭМДЕГ, НДЕГ, АТГ-аас мэдээлэл авах албан бичиг хүргүүлж, хариу авсан.



2.2.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны товч мэдээлэл

- 2024.10.04 ЭМДЕГ, НДЕГ-ын мэдээллийг сонсож, ажлын хэсгийн удирдамж баталсан. Төлөвлөгөөг бусад ажлын хэсгүүдтэй уялдуулан батлахаар тогтов.
- 2024.10.16 ЭМЯ, ЭМДҮЗ, ЭМДЕГ, Улсын I, III төв эмнэлэг, аймаг, нийслэл, дүүрэг, сумдын төлөөлөл мэдээлэл өгсөн.
- 2024.12.04 УИХ-ын 98 дугаар захирамжаар байгуулагдсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах” ажлын хэсэгтэй хамтарсан хурал хийж, хамтран ажиллахаар тогтсон.
- 2025.01.15 ГБХНХ-ын сайд Л.Энх-Амгалан нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, нөхцөл байдлын талаар мэдээлэл хийсэн.



14. УИХ-ын даргын захирамж 2024.09.05, №115

Иргэний хуулийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.09.18 Ажлын хэсгийн ахлагч орон нутагт ажиллаж байна.
- 2024.11.27 Ажлын хэсгээс “Иргэний хууль тогтоомж: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт уулзалт-хэлэлцүүлгийг Иргэний хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор зохион байгуулсан.
- Хэлэлцүүлэгт УДШ, ХЗБХЯ, УБЕГ, Монголын ОУ-ын Арбитр, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи, СЗХ, ХЗҮХүрээлэн, Монополийн эсрэг газар, Монголын нотариатчдын танхим, Монголын хуульчдын холбоо, МӨХ, МУИС, Шихихутуг Их сургуулийн төлөөлөл оролцсон ба илтгэл, танилцуулгыг МУИС-ийн эрдэмтэн, судлаачид “Монгол Улсын өв залгамжлалын эрх зүйн хөгжил”, “Гэрээний эрх зүйн асуудал”, ХЗДХЯ-наас Арилжааны хуулийн төслийн талаар, Монголын ОУ-ын арбитраас “Иргэний хууль тогтоомж: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам”, Монголбанкнаас “Монгол Улсын төлбөрийн систем” сэдвээр тус тус танилцуулж, хэлэлцүүлсэн.



15. УИХ-ын даргын захирамж 2024.12.02, №292

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсвийн төслийг боловсруулах болон төсвийн гүйцэтгэлийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх журмын талаар санал, дүгнэлт гаргаж, төсвийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах чиглэлээр хуулийн төсөл боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2025.01.20 Хуралдаанаар ажиллах хүрээ, төлөвлөгөөгөө хэлэлцсэн. Мөн ажлын дэд хэсгийг байгуулж, гүйцэтгэх ажлын талаар хэлэлцсэн.
- Ажлын дэд хэсгээс шаардлагатай судалгаа, тооцооллуудыг боловсруулан тухай бүр ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлж байна.
- 2025.01.28, 30 ААНОАТ, ХХОАТ болон НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна.

2.3. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	БСШУСБХ-ны тогтоол 2024.10.15, №01 “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1-д тэгж, хүртээмжтэй, чанартай боловсрол зорилтын хүрээнд туссан Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 6 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч Ч.Ундрэм Гишүүд: Ц.Мөнхтуяа, Д.Рэгдэл, М.Сарнай, Б.Хэрлэн, С.Эрдэнэбат
2.	БСШУСБХ-ны тогтоол 2024.10.15, №02 Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 8 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч О.Батнайрамдал Гишүүд: Ш.Бямбасүрэн, Ж.Галбадрах, Г.Дамдинням, Б.Найдалаа, О.Саранчулуун, М.Сарнай, С.Эрдэнэбат
3.	АҮББХ-ны тогтоол 2024.11.13, №01 “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 12 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Л.Мөнхбаясгалан Гишүүд: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Х.Жангабыл, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга, Г.Очирбат, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, Д.Энхтүвшин
4.	АҮББХ-ны тогтоол 2024.11.13, №02 “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 11 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхтуяа Гишүүд: М.Бадамсүрэн, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Пунсалмаа Д.Пүрэвдаваа, Б.Уянга, Г.Лувсанжамц, Д.Үүрийнтуяа, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг
5.	АҮББХ-ны тогтоол 2024.11.19, №05 “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 13 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбаатар Гишүүд: М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Х.Жангабыл, Г.Лувсанжамц, Л.Мөнхбаясгалан, П.Мөнхтулга, Г.Очирбат, Б.Тулга, Б.Уянга, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг
6.	АҮББХ-ны тогтоол 2024.12.24, №08 Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 13 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: Б.Уянга Гишүүд: Д.Батлут, Д.Батбаяр, Д.Жаргалсайхан, С.Замира, Ж.Золжаргал, Г.Лувсанжамц, Г.Очирбат, Б.Пунсалмаа, Д.Пүрэвдаваа, Д.Үүрийнтуяа, Д.Энхтуяа, М.Энхцэцэг
7.	БОХХААБХ-ны тогтоол 2025.01.14 №2 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 6 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч Ж.Бат-Эрдэнэ Гишүүд: М.Бадамсүрэн С.Ганбаатар М.Ганхүлэг С.Замира У.Отгонбаяр
8.	АҮББХ-ны тогтоол 2025.01.15 №02 Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 13 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч М.Бадамсүрэн Гишүүд: Д.Батбаяр П.Ганзориг М.Ганхүлэг Х.Жангабыл С.Замира Г.Лувсанжамц Г.Очирбат Б.Пунсалмаа Д.Үүрийнтуяа Д.Энхтүвшин М.Энхцэцэг Д.Энхтуяа

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
9.	БОХХААБХ-ны тогтоол 2025.01.21 №08 Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	/УИХ-ын 7 гишүүн/ Ажлын хэсгийн ахлагч: С.Ганбаатар Гишүүд: Р.Сэддорж М.Ганхүлэг С.Замира М.Мандхай А.Ундраа Б.Уянга

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсэг



1. БСШУСБХ-ны тогтоол 2024.10.15 №01

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.1-д тэгж, хүртээмжтэй, чанартай боловсрол зорилтын хүрээнд туссан Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явцад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.10.30 Ажлын хэсэг анхны хуралдаанаа хийж, Боловсролын ерөнхий газрын мэдээлэл сонсож, удирдамжийн төслийг хэлэлцсэн.
- 2024.11.13 БСШУСБХ-ны хуралдаанаар ажлын хэсгийн удирдамжийн төслийг баталсан.
- 2024.11.20 Боловсролын ерөнхий газар, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Барилгын хөгжлийн төвийн мэдээлэл-ийг ажлын хэсгийн хуралдаанаар сонссон.
- 2025.01.23 21 аймгийн Засаг дарга нарт албан тоот хүргүүлсэн.

2. БСШУСБХ-ны тогтоол 2024.10.15 №02

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаа, журмын биелэлтэд хяналт шалгалт хийх, холбогдох санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.11.07 Хуралдаанаар Боловсролын зээлийн сангийн мэдээлэл сонсож, ажлын хэсгийн удирдамжийн төслийг хэлэлцсэн.
- 2024.11.13- БСШУСБХ-ны хуралдаанаар удирдамжийг хэлэлцэн баталсан.
- 2025.01.07- Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаатай газар дээр танилцаж, Боловсролын сайдад асуулт тавьсан.
- 2025.01.15-Боловсролын зээл олгох журмын танилцуулга, мэдээлэл сонссон.
- 2025.01.22-нд Боловсролын зээлийн сангийн журмын биелэлтийн талаар мэдээлэл сонссон.

3. АҮББХ-ны тогтоол 2024.11.13 №01

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2024.12.17 болон 2025.01.20-нд ажлын хэсэг 2 удаа хуралдсан.
- 2024.12.17- Хуралдаанаар ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөг хэлэлцэж баталсан. Мөн холбогдох төрийн байгууллагуудын мэдээлэл сонссон.
- 2025.01.20-Хуралдаанаар Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн нөхцөл байдал, түүхий эдийн нөөц болон Монгол Улсын Засгийн газар БНЭУ-ын “Экспорт-Импорт” банк хоорондын зээлийн хэлэлцээрийн талаар холбогдох мэдээлэл сонссон.
- 2025.01.22- АҮББХ-ны хуралдаанаар Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах тухай Засгийн газарт чиглэл өгөх тогтоолын төслийг баталсан.

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсэг



4. АҮББХ-ны тогтоол 2024.11.13 №02

“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- Ажлын хэсгийн удирдамжийн төслийг боловсруулан гишүүдэд хүргүүлсэн.
- 2024.12.04 Хуралдаанаар ажлын хэсгийн үйл ажиллагааны талаар ерөнхий танилцуулга хийж, дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн, хамтран ажиллах талаар санал солилцож, төлөвлөгөөгөө хэлэлцэн баталсан.
- 2025.01.22-ны “Тавантолгой түлш” ХХК-иас санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, үйлдвэрлэл, технологийн талаарх мэдээлэл авсан.

5. АҮББХ-ны тогтоол 2024.11.19 №05

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- Ажлын хэсгийн удирдамжийн төслийг боловсруулж, Байнгын хорооны 2024.12.09-ний өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан.
- 2025.01.15-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

6. АҮББХ-ны тогтоол 2024.12.24 №08

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцах, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2025.01.06-10 Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний 08 дугаар тогтоолоор “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоол батлагдсан.
- 2025.01.07 Ажлын хэсгийн удирдамжийг батлах тухай тогтоол батлагдсан.
- 2025.01.29-31 Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Хөдөө орон нутагт ажиллах удирдамжийн төсөл боловсруулсан.
- 2025.01.27 Ажлын хэсгийг дэмжих баг байгуулах, төлөвлөгөө болон удирдамжийн төсөлд гишүүдийн санал оруулах, эцэслэн батласан.

2.2.1. Үйл ажиллагаа үргэлжилж буй ажлын хэсэг



8. АҮББХ-ны тогтоол 2025.01.15 №02

Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын хүрээнд холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- 2025.01.29-Хуралдаанаар ажлын хэсгийн төлөвлөгөөг хэлэлцэн баталсан. Мөн Хөгжлийн шийдэл ТББ-ын төлөөллийн судалгааны тайлан сонссон.
- Үйл ажиллагааны явцын мэдээлэл:
- Өрхийн, бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх бодлогын шийдлийг боловсруулах ажлын хэсэг Зүүн бүс нутагт ажиллаж байна. Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн 2025.01.31-Дорнод аймгийн иргэдтэй уулзаж, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, хууль тогтоомжийг шинэчлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн аймгийн удирдлагууд, сумдын Засаг дарга нар, агентлагуудтай өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх асуудлаар санал солилцсон.
- Хэнтий, Сүхбаатар аймгуудын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон эрчим хүч, зам, барилга, уул уурхайн салбарын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулах төлөвлөгөөтэй байна.



9. БОХХААБХ-ны тогтоол 2025.01.21 №08

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

Товч мэдээ:

- Ажлын хэсэгт шаардлагатай мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлын хүрээнд ХХААХҮЯ, БОУАӨЯ-дад тус салбаруудад олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг төсөл хөтөлбөр нэг бүрээр, байршил, хугацаа, гэрээний үндсэн дүн, тодотгосон дүн, санхүүжилтийн мэдээлэл, зардлын зүйл, төрлөөр зээлийн бичиг баримт, аудитын дүгнэлт, үр дүн хүртэгчийн явцын болон эцсийн үнэлгээний нотлох баримтын хамт дэлгэрэнгүй байдлаар ирүүлсэн.
- Сангийн яаманд дээрх 2 салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн, одоо хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар нэгтгэн ирүүлэх, харин Үндэсний аудитын газарт дээрх салбаруудад олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдэд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг сүүлийн 5 жилийн байдлаар нэгтгэн ирүүлэх албан бичгийг тус тус хүргүүлсэн.
- СЯ, ҮАГ, ХХААХҮЯ, БОУАӨЯ-аас мэдээллийг 2 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч нэгтгэн боловсруулж Ажлын хэсэгт танилцуулахаар төлөвлөсөн.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН ТАЛААР



- Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан 2024 оны ээлжит чуулганы завсарлагааны болон намрын ээлжит чуулганы хугацаанд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 21 гишүүн 97 асуудлаар 21 удаа асуулга, давхардсан тоогоор Улсын Их Хурлын 28 гишүүн 129 асуудлаар 28 удаа асуулт тавьсан байна.

Д/д	УИХ-ын гишүүний нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуултын агуулга	Хамрагдсан асуудлын тоо	Асуулт тавьсан огноо	Хариу ирүүлсэн огноо
1	Г.Ганбаатар	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Шинэ хилийн боомт нээх талаар	3	2024.10.01 №20	2024.10.17 №ХЭГ/1998
2	С.Ганбаатар	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан	Геологи, хайгуулын салбарт баримтлах бодлого, төлөвлөлт, бүтцийн өөрчлөлт хийх талаар	4	2024.10.21 №22	2025.01.15-01/118
3	О.Номинчимэг	Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хэрэгжилтийн талаар	1	2024.11.04 №26	2024.11.21 1/1893
4	О.Номинчимэг	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Эрүүл мэндийн дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар	1	2024.11.04 №27	2024.11.27 №1а/4954
5	О.Номинчимэг	Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийн талаар	1	2024.11.06 №28	2024.11.21 1/1894
6	О.Номинчимэг	Монгол банкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийн талаар	3	2024.11.06 №29	2024.12.03 1а/903
7	С.Эрдэнэболд	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь	Улаанбаатар хотын усны чанарын тухай	5	2024.11.11 №34	2024.11.22 №01/1451
8	Х.Ганхуяг	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан	Хуулийн биелэлттэй холбоотой мэдээлэл ирүүлэх тухай	2	2024.11.20 №36	2024.12.11 №01/1293
9	Х.Ганхуяг	Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан	Мэдээлэл ирүүлэх тухай	3	2024.11.20 №37	2025.01.06
10	Ц.Мөнхтуяа	Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн	Боловсролын ерөнхий хуулийн зарим заалтын хэрэгжилтийн талаар	3	2024.11.20 №38	2024.12.18
11	Ц.Мөнхтуяа	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролын ерөнхий хуулийн зарим заалтын хэрэгжилтийн талаар	4	2024.11.21 №39	2024.12.12 №1/2678
12	С.Эрдэнэболд	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Монгол хүний эрүүл мэндийн тухай	9	2024.11.22 №40	2024.12.06 №1а/5152
13	Ц.Мөнхтуяа	Боловсролын сайд П.Наранбаяр	Монгол Улсын Засгийн газрын 2024.01.17-ны өдрийн 25 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	3	2024.11.25 №41	2024.12.23

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ

Д/д	УИХ-ын гишүүний нэр	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуултын агуулга	Хамрагдсан асуудлын	Асуулт тавьсан огноо	Хариу ирүүлсэн огноо
14	Л.Мөнхбаясгалан	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Цагаан Уул - Өлзий боомтын бүтээн байгуулалтын талаар	6	2024.11.27 №42	2024.12.18
15	Л.Мөнхбаясгалан	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Зарим төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон үйлдвэрийн газрын талаар	4	2024.11.27 №43	2025.01.07
16	Б.Бат-Эрдэнэ	Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд	Мэдээлэл ирүүлэх тухай	6	2024.11.27 №44	2024.12.18
17	О.Батнайрамдал	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар	8	2025.01.07	2025.01.20 1/248
18	Б.Жаргалан	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар	3	2025.01.14	Хугацаа болоогүй
19	А.Ариунзаяа	Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл	Шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянуулах тухай	1	2025.01.22	Хугацаа болоогүй

- БСШУСБХ-ны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж тавьсан 10 дугаар асуулгын хариуг хэлэлцсэн.
- Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлийн 113.2-т заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар асуулгын хариуг сонсоогүй болно.
- Улсын Их Хурлын гишүүний асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн байдал:
- БСШУСБХ-ны 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас “Асуулт тавих тухай” Боловсролын сайд П.Наранбаярт хандаж тавьсан 09 дүгээр асуултын хариуг;
- АҮББХ-ны 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар” Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандаж тавьсан 12 дугаар асуултын хариуг тус тус сонссон.
- Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн асуултын хариуг хэлэлцсэнтэй холбогдуулан АҮББХ-ны 2024 оны 01 дүгээр тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах,

4.1. ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ



Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдын 3 удаа хийсэн мэдээлэлтэй холбогдуулан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 16 гишүүн 52 асуулт асууж, үг хэлсэн байна. Энэ хугацаанд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбоотойгоор нийт 5 иргэнээс ирүүлсэн асуултын тоо 20 болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙСЭН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Сэдэв	Мэдээлэл хийсэн сайд	Мэдээллийг сонссон огноо	Асуулт асууж, үг хэлсэн гишүүдийн тоо	Нийт асуултын тоо
ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ					
1	“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Боомтын сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн талаар;	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр	2024.10.25	6	16
2	2024-2025 оны евелжилт, хаваржилтын бэлтгэл ажлын явцын талаар;	Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга С.Амарсайхан	2024.11.29	10	36
3	Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааны хүрээнд хийгдсэн “Шил” ажиллагааны хэрэгжилтийн талаар;	Монгол Улсын Ерөнхий сайд, Л.Оюун-Эрдэнэ	2024.11.27	8	22

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт, санал хэлсэн гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД					
1	ИЦББХ 2024.10.16	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Н.Учрал	Үндэсний хиймэл дагуул төслийн танилцуулга	6	16
2	БОХХААБХ 2024.10.24	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр	Өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явц байдлын талаарх мэдээлэл	10	20
3	БОХХААБХ 2024.10.24	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, салбарын үйл ажиллагааны талаар	10	27
4	ҮББХ 2024.10.30	Тавантолгой түлш ХХК-ийн Ерөнхий инженер Ц.Алтансүх	Тавантолгой түлш ХХК-ийн танилцуулга	6	15
5	НББХ 2024.11.05	Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ-ийн дарга Т.Мөнхсайхан	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан	18	74
6	АҮББХ 2024.11.13	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрс угаах, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл	19	48
7	АҮББХ 2024.11.27	Тавантолгой түлш ХХК-ийн Ерөнхий инженер Ц.Алтансүх	Тавантолгой түлш ХХК-ийн үйлдвэрлэл, техник технологийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэл	9	19
8	БОХХААБХ 2024.12.10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр	Мал, махны бэлтгэн нийлүүлэлт, нөөц, экспортын талаар	10	34
9	БОХХААБХ 2024.12.10	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр	Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгосон зээл, зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэл	8	26
10	АҮББХ 2024.12.17	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан	Үйлдвэрлэл, технологийн паркуудын үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явцын талаарх мэдээлэл	14	46
11	ИЦББХ 2024.12.18	Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД И.Батхүү	Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх талаар	6	20
12	АБГББХ 2024.12.18	/хаалттай/	-	-	-
13	ИЦББХ 2024.12.18	Харилцаа холбооны зохицуулах хорооны Ажлын албаны дарга А.Лувсан-Очир	Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	3	8
14	БСШУСБХ 2024.12.18	Боловсролын сайд П.Наранбаяр	Боловсролын салбарын эрх зүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх ерөнхий мэдээлэл болон боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн талаар	7	25
15	ИЦББХ 2024.12.24	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар	5	11
16	БОХХААБХ, АҮББХ-ны хамтарсан 2024.12.24	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа	Байгаль орчны салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл	24	79

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ

№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт, санал хэлсэн гишүүд / давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
17	ЭЗБХ 2025.01.07	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат	Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн санхүү, төсөв, татвар, гааль, хөрөнгө оруулалт, даатгалын бодлогын хэрэгжилт, гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гадаад, дотоод өрийн хэмжээ, өрийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	8	20
18	ЭЗБХ 2025.01.07	Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр	Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт болон тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн хөрөнгө оруулалт, хэрэгжилт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	12	27
19	БСШУСБХ 2025.01.14	Боловсролын сайд П.Наранбаяр	Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	15	39
20	БОХХААБХ, АҮББХ-ны хамтарсан 2025.01.14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл	16	44
21	БОХХААБХ, АҮББХ-ны хамтарсан 2025.01.14	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга	Үйлдвэрлэлийн ус хангамж, ус ашиглалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээлэл	6	18
22	ИЦББХ 2025.01.14	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Дэлгэрнараран, Үндэсний дата төв болон И-Монгол академийн захирал М.Баттулга, Мягмарнараран	Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар мэдээлэл	3	13
23	АБГББХ 2025.01.15	/хаалттай/	-	-	-
24	ЭЗБХ 2025.01.15	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголт, уул уурхайн салбараас хүртэх үр өгөөжийн талаар орон нутгийн иргэдийг мэдээлэлжүүлэх, уул уурхайн биржийн арилжаа болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаарх мэдээлэл	9	18
25	АҮББХ 2025.01.15	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн хэрэгжилт болон дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зээл олголт, эргэн төлөлт, зээлийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэл	13	37
26	БОХХААБХ 2025.01.21	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД Т.Жамбалцэрэн	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	17	21
27	НББХ 2025.01.22	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл	34	37
НЭГДСЭН ДҮН				288	742

5.1. ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ

Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйл

• 2024 оны 08 дугаар сарын 06-нд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 22 гишүүнээс Улсын Их Хурлын даргад хандан Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгуулах хүсэлт гаргасан. Үүний дагуу 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо хуралдаж, хяналтын сонсголын сэдвийг “Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хэмээн тогтоосон. Энэ сонсголыг 2024 оны 11 дүгээр сарын 20-нд зохион байгуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг даргалж, хяналтын сонсголын дараа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нөхөн төлбөрийн талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хандах эсрэг конвенцын орчуулгыг нягтлах шаардлагын талаар байр сууриа илэрхийлсэн.



• 2024 оны 12 дугаар сарын 18-нд, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоолоор чиглэл өгсөн.

5.2. Ерөнхий хяналтын сонсгол


Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 29 дугаар зүйл

• 2025 оны 02 дугаар сарын 03-04-нд, Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо “Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр ерөнхий хяналтын сонсгол зохион байгууллаа. Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн даргалсан Сонсголын гол зорилго нь төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн саналыг сонсож, шийдвэр гаргах түвшинд нэгдсэн ойлголттой болох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах асуудлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл өгөхөөр ажиллаж байна.



• Ажлын хэсэг ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталж, бэлтгэл ажлын хүрээнд Агаарын бохирдол-хүн амын эрүүл мэнд (Амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх), “Утааны асуудал: Стандарт, хяналт (Зуух, түлшний технологи)”, “Утааны асуудал: Эрх зүйн орчин, бодлого шийдвэрийн хэрэгжилт, санхүүжилт, хариуцлага”, “Утааны асуудал: Зуух, түлшний технологийн шийдлүүд” сэдвээр дөрвөн цуврал хэлэлцүүлэг зохион байгуулсныг дурдаад дээрх хэлэлцүүлэгт нийт 300 гаруй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл оролцож, 215 иргэн, аж ахуй нэгжийн төлөөллөөс 87 иргэн асуулт асууж, санал хэлж, 28 иргэн, аж ахуйн нэгж өөрсдийн шийдэл, шинэ санаачилга, бүтээлийн танилцуулга, илтгэлээ танилцуулсан.

6.1. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГАД ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ БОЛГОСОН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫГ ХЯНАЛТАД АВСАН ТАЛААР



- 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 162 хуулийн 755 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 150 тогтоолын 881 заалт, Байнгын болон дэд, түр хорооны 106 тогтоолын 795 заалтын биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.
- Улсын Их Хурлын тогтоол: 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон Улсын Их Хурлын 7 тогтоолыг хяналтад авсан. Үүнд:

д/д	УИХ-ын тогтоолын огноо, дугаар	Тогтоолын агуулга
1.	2024.10.17-ны өдрийн 34 дүгээр тогтоол	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2025 онд баримтлах үндсэн чиглэл
2.	2024.10.18-ны өдрийн 35 дугаар тогтоол	Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай
3.	2024.11.08-ны өдрийн 39 дүгээр тогтоол	Засгийн газарт чиглэл өгөх тухай
4.	2024.11.08-ны өдрийн 41 дүгээр тогтоол	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
5.	2024.12.12-ны өдрийн 52 дугаар тогтоол	Засгийн газарт чиглэл өгөх тухай
6.	2024.12.12-ны өдрийн 54 дүгээр тогтоол	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулах авах зарим арга хэмжээний тухай
7.	2024.12.27-ны өдрийн 58 дугаар тогтоол	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай

- **Байнгын, дэд хорооны тогтоол:** Засгийн газар, холбогдох байгууллагад үүрэг, чиглэл болгосон нийт 106 тогтоолын 795 заалтын биелэлтэд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороодын 7 тогтоолын 43 заалтыг нэмж хяналтад авсан болно. **Үүнд:**

д/д	Байнгын хороо	Тогтоолын огноо, дугаар	Тогтоолын агуулга
1.	ЁЗДБХ	2024.11.06-ны өдрийн 06 дугаар тогтоол	УИХ-ын ЁЗСХБХ-ны 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг сонссонтой холбогдуулан “Тогтоолын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай”
2.	ХЗБХ	2024.12.18-ны өдрийн 09 дүгээр тогтоол	““Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” асуудлаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
3.	ЭЗБХ	2024.12.24-ний өдрийн 07 дугаар тогтоол	Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хүрээнд “Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай”
4.	ЭЗБХ	2025.01.15-ны өдрийн 09 дүгээр тогтоол	Ашигт малтмал, газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй ашгт малтмал, газрын тосны тусгай зөвшөөрөл эзэмшигчийн улсын төсөвт төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30-аас доошгүй хувийг хуваарилах чиглэлээр “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
5.	АҮББХ	2025.01.22-ны өдрийн 05 дугаар тогтоол	“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлж, үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
6.	ИЦББХ	2025.01.14-ний өдрийн 01 дүгээр тогтоол	УИХ-ын ИЦББХ-ны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг хэлэлцээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай”
7.	ИЦББХ	2025.01.14-ний өдрийн 02 дугаар тогтоол	УИХ-ын ИЦББХ-ны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг хэлэлцээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай”

7.1. ТӨСВИЙН ХЯНАЛТ

1. Төсвийн төлөвлөлтийн хяналт



- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д зааснаар нийт 39 Төсвийн ерөнхийлөн захирагчид тухайн жилийн төсвийн саналыг 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд ирүүлэх үүрэгтэй.
- Энэхүү хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны төсвийн төслийн саналыг хүлээн авч, батлагдсан төсвийн хязгаартаа багтсан эсэхэд, 2023, 2024 оны батлагдсан төсөвтэй харьцуулан зардлын зүйл бүрээр нарийвчилсан дүн шинжилгээ хийснээр Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төлөвлөлтийн байдал, бодлогын уялдаа холбоог тодорхойлох боломж бүрдсэн.

2. Төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны хяналт



- Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох хууль, тогтоомжийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурал уг төслүүдийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх хэсэгт “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын ээлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж заасны дагуу хэлэлцэн 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан. Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь хориг тавьсан. Үүний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгож, цаашид авах арга хэмжээний тогтоолыг баталсан. Уг тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох хууль, тогтоомжийн төслүүдийг дахин өргөн мэдүүлсэн.

Анх өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хувьд:



- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий төсвийн орлого, урсгал зардал, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажлын дэд хэсгүүд байгуулагдан 21 саналыг гарган ажилласан.

Дахин өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хувьд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий 6 дэд ажлын хэсэгт хуваагдан дэд ажлын хэсэг бүрийн санал, дүгнэлтийг сонсож, тодорхой зарчмуудыг баримтлана ажилласан.



- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай анх өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасныг үндэслэн МУИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 347 дугаар захирамжаар батлагдсан “Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу шинжилгээ хийгдэж, танилцуулга бэлтгэгдсэн.
- Дүн шинжилгээнд төсвийн төслийг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу “Улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлого”-д нийцсэн эсэх, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангасан эсэх, Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд нийцсэн байдал зэргийг шинжилж, дүгнэлт гаргасан. Түүнчлэн төсвийн төслийг макро эдийн засгийн болон өргөн мэдүүлсэн төсөв, өмнөх онуудын төсөвтэй харьцуулснаар шинжилгээ хийгдсэн болно.

7.2. МАКРО ЭДИЙН ЗАСАГ, ТӨСВИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Макро эдийн засгийн мэдээ



- Монгол Улсын макро эдийн засгийн 2024 оны III улирлын тойм танилцуулгыг Монголбанк, Сангийн яам, Үндэсний статистикийн хорооны албан эх сурвалжийг ашиглан бэлтгэж, Байнгын хороод, УИХ-ын гишүүдийг мэдээллээр ханган ажилласан. Макро эдийн засгийн тойм танилцуулгад бодит сектор, нэгдсэн төсөв, Засгийн газрын өр, гадаад худалдаа, мөнгө, санхүү, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдтэй холбоотой цогц мэдээллийг багтааж, Улсын Их Хурлын цахим хуудас /www.parliament.mn/-д олон нийтэд нээлттэй байршуулсан.

<https://www.parliament.mn/nn/63635/>

Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ



- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны 10, 11, 12 сарын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн Байнгын хороод, УИХ-ын гишүүдийг тухай бүр мэдээллээр ханган ажилласан. Танилцуулгад нэгдсэн төсвийн орлого, зарлагын тооцооллыг боловсруулж, тэнцвэржүүлсэн тэнцэл, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллүүд тусгагдсан. Уг танилцуулгыг Улсын Их Хурлын цахим хуудас /www.parliament.mn/-д олон нийтэд нээлттэй байршуулсан.

<https://www.parliament.mn/nc/477/>

Гадаад худалдааны сарын мэдээ



- Монгол Улсын экспорт, импорт болон гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн экспорт, импортын тоо хэмжээ, үнэ ба татварын орлогын 2024 оны 10, 11, 12 сарын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, товч танилцуулгыг бэлтгэсэн. Танилцуулгыг улсын болон орон нутгийн гадаад үйл ажиллагаатай холбоотой татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээ, татварын өр, дутуу төвлөрсөн орлогын тайлбар, холбогдох тооцооллын талаарх мэдээллийг Татварын Ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газраас авч боловсруулан Улсын Их Хурлын цахим хуудас /www.parliament.mn/-д олон нийтэд нээлттэй байршуулсан.

<https://www.parliament.mn/nc/623/>

УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ



- Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл”-д дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолын 2.3 дахь хэсэгт заасны дагуу хөгжлийн бодлогын тэргүүлэх салбар, чиглэлийг тодорхойлж, хөгжлийн төсөл, арга хэмжээг эрэмбэлэн тусгасан эсэхэд шинжилгээ хийсэн. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл нь “Эдийн засаг”, “Бүсчилсэн хөгжил”, “Хүний хөгжил” болон “Хүний эрхийг дээдэлсэн засаглал”-ын гэсэн 4 үндсэн бодлогын тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэд бүтэц, бүтээн байгуулалтын 14 мега төсөл, тогтвортой хөгжлийг хурдасгах 149 төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж, салбарын реформуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, төсвийн ерөнхийлөн захирагч /ТЭЗ/-ийн 28 зорилт, хөтөлбөрийн 63 зорилт болон 318 арга хэмжээний үр дүн, 364 шалгуур үзүүлэлт, харгалзах бодлогын үндэслэл, шаардагдах санхүүжилтийн хэмжээ, түүний эх үүсвэр болон хариуцагч байгууллагуудыг тусгасан байна.
- 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, 2025 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх арга хэмжээ, “2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-ийн төсөлд тусгагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ, “2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-ийн төсөлд тусгагдсан нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ түүний нийт санхүүжилтэд эзлэх хувийг харьцуулан тус тус гаргаж танилцуулга бэлтгэсэн.

Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

- Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд дүн шинжилгээ хийж, байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлсэн. Мөн 38 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төслийн зарлагын талаар дүн шинжилгээ хийж, танилцуулга, мэдээлэл бэлтгэн Байнгын хороодод хүргүүлж, тухай бүр хуралдаанаар хэлэлцүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл Засгийн газраас өргөн мэдүүлсэн тохиолдолд төсөлд дүн шинжилгээ хийж, холбогдох тооцоо судалгааг гаргах, дүгнэлт бэлтгэн Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх.

- Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т заасны дагуу төсвийн тодотголын төсөл нь тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т заасан шаардлагыг хангасан эсэхэд дүн шинжилгээ хийж, товч танилцуулгыг бэлтгэн холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн.

7.3. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санал, зөвлөмж

Монгол Улсын Их Хурлын
Хяналт шалгалтын тухай
хуулийн 21-24 дүгээр зүйл



- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар хүлээсэн хуулийн төсөлд хараат бус, бие даасан дүгнэлт, зөвлөмж гаргах үүргээ хэрэгжүүлэн ажиллаж дахин өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлтийг тус тус Улсын Их Хуралд хүргүүлсэн.
- Мөн Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тухай мэдээлэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, 2024 оны төсвийн тодотголд өгсөн дүгнэлт, зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд өгсөн дүгнэлт, Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлтийг тус тус хүргүүлсэн.
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, холбогдох газруудад хуулийн хугацаанд хүргүүлж, улмаар Улсын Их Хурлын цахим хуудсанд (<https://www.parliament.mn>) тухай бүр нийтэлсэн.
- Хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ Зөвлөлийн дарга, гишүүд төсвийн бодлогын хэрэгжилтээс гадна эдийн засгийн дотоод, гадаад нөхцөл байдал, эрсдэлийг тодорхойлох зорилгоор судалгаа хийж, судалгааны ажлууд, тайлантай танилцах ажлыг гүйцэтгэсэн.

Зөвлөлийн хуралдаан

- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд өөрийн үйл ажиллагааны чиглэлээр 4 удаагийн хуралдаан, дотоод зохион байгуулалтын шинжтэй 3 удаагийн хурал, уулзалтыг зохион байгуулж холбогдох асуудлуудыг хэлэлцэн нийт 4 чиглэлийн хүрээнд дүгнэлт, зөвлөмж бүхий шийдвэрийг Төсвийн байнгын хороо, холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилт

- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцүүлэн холбогдох хуулийн төсөлд дүгнэлт, зөвлөмжийг хуулийн хугацаанд хүргүүлж ажилласнаар нийгэмд болон Улсын Их Хурлын хүрээнд төсвийн хяналтыг сайжруулах, алдагдалгүй, өр үүсгэдэггүй төсөвтэй болох, нийтийн санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болж байна. Тус зөвлөлөөс өгсөн санал, зөвлөмжид нийцсэн алдагдалгүй төсөв батлагдсанаар цаашид ч эерэг тэнцэл бүхий төсөв батлагддаг болох сайн жишиг тогтож, төсвийн сахилга бат сайжирч байна.

Олон нийттэй харилцах, Зөвлөлийн үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр хийгдсэн ажил

- Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь төсвийн бүрдлийг хангахад чиглэсэн эдийн засгийн бодлого явуулах, төсвийн сахилга батыг бэхжүүлэх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн мөн чанарыг нийгэмд таниулах, энэ хүрээнд төсвийн алдагдлыг багасгаж, өр үүсэхээс сэргийлэх бодлогын хүрээнд Улсын Их Хурал, Засгийн газар, бусад төрийн захиргааны төв байгууллагатай, мөн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээрх Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай санал, туршлага солилцох, хамтын ажиллагааг тогтоох, өргөжүүлэх, ижил түвшний байгууллагуудын зохион байгуулж буй арга хэмжээнд оролцох зэрэг олон талт хамтын ажиллагааг хангаж ажилласан.
- Түүнчлэн “Монгол Улсын 2025 оны төсвийн төлөвлөлт” сэдэвт хэлэлцүүлгийг Нээлттэй нийгэм форумтай хамтран холбогдох яам, агентлаг, төрийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, их, дээд сургуулийн багш нар, эрдэмтэн судлаачид, хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн төлөөллийг оролцуулан өргөн хүрээнд зохион байгуулсан.
- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс танилцуулсан зөвлөмж, илтгэлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлуудыг тусган Улсын Их Хурлын гишүүд болон олон нийтэд танилцуулсан.

